

**“Улаан дэвтэр” дэх Хятадын бурханы шашны түүхэнд
холбогдох зарим мэдээний тухайд**

*Дэмчигмаа О. / МУИС /
Хүүдагуул / Улаанхадын дээд сургууль /*

Төвдийн түүхч Цалба Гунгаадоржийн 1346 онд төвдөөр бичсэн “Улаан дэвтэр” бол Энэтхэг, Хятад, Монгол, Төвдийн түүхтэй холбогдох мэдээ сэлт хийгээд бурханы шашны бүлгүүдийн үүсэл дэлгэрлийн түүхийг агуулсан дундад эртний, нэртэй сурвалж бичиг юм.

Эл өгүүлэлдээ бид “Улаан дэвтэр” дэх сураг зангид үндэслэж бурханы шашны тоололд¹ холбогдох зарим он тооллын асуудал, Хятад оронд бурханы шашны анхлан дэлгэрсэн цаг үеийн асуудал, мөн Зүүн Цинь улсын үеийн их шүтээнүүдийн тухай, ялангуяа мэргэн бандида Гүмараши² болон Занданзуугийн талаар голчлон өгүүлэхийг зорилоо.

1. Бурханы шашны он тоололд холбогдох зарим асуудал.

“Улаан дэвтэр”-т “Чжоу улсын дөрөвдүгээр эзэн Чжао ван хаан суугаад хорин жил өнгөрөхөд модон бар жилийн дөрвөн сарын шинийн найманд Энэтхэг оронд ялж төгс нөгчсөн бээр лагшин мэндэлвэй”³ хэмээн тэмдэглэсэн байна. Энд дурдаж буй Чжао ван бол НТӨ 995 оны улаан нохой жилд хаан сууринд суужээ⁴.

¹ Бурханы шашны тоолол нь анх Бурхан Шагжамунийн гаслангаас нөгчсөнтэй холбоотойгоор үүссэн бөгөөд эрт эдүгээгийн олон үзэл байдаг. Төвдөөр *bstan rtsis* хэмээх энэ нь төвд хэлт утга зохиолын нэг төрөл зүйлд багтдаг.

² Гүмараши бол Хятадын Цинь улсын үед амьдарч байсан. Цинь улс нь Хятадын Цинь улсын үед байсан 16 улсын нэг, НТ 350-417 хооронд оршиж байжээ. Түрүү, Хожуу хоёр Цинь гэж түүхэнд нэрлэгдэж байсан хийгээд Түрүү Цинь улсыг НТ 350 онд Фу Хун байгуулсан. НТ 383 онд түшмэл нь хаан төрийг булаагаад НТ 384 онд Хожуу Цинь улсыг байгуулсан байна.

³ Дунгарлуvsандринлэй. “Улаан дэвтэр”-ийн чухал үгсийн товч тайлбар. Үндэстний хэвлэлийн хороо. Бээжин. 2004 он. 10 дугаар нүүрт.

⁴ Хятад монгол толь. Үндэстний хэвлэлийн хороо. Бээжин. 2005 он. 1819 дүгээр нүүрт.

Харин бурхан Шагжамунийн мэндэлсэн он жилийн талаар Улаан дэвтэр-т “...үүнээс хойш хорин жил өнгөрөөд модон бар жилийн шинийн найманд мэндэлсэн” гэж тэмдэглэсэн байх агаад Хятадад дэлгэрсэн “Дөчин хоёр хэсэгт”⁵ судрын 74 дүгээр нүүрийн “б” талд “...Жу Чжао вангийн хорин дөтгөөр он модон бар жилийн шинийн найман дор” гэсэн мэдээний жил, сар, өдөр нь “Улаан дэвтэр”-ийнхтэй таарч буй боловч “Улаан дэвтэр”-т “...хорин жил өнгөрөөд...”, “Дөчин хоёр хэсэгт”-д “...хорин дөрвөн жил өнгөрөөд...” гэсэн мэдээнүүдийн аль алинд нь модон бар жил тохиохгүй. Хорин жил өнгөрсөн гэдгээр бодвол НТӨ 975 оны улаагчин туулай жил, хорин дөрвөн он гэдгээр бодвол НТӨ 972 оны шарагчин үхэр жил тохионо.

Бурхан Шагжамуни хэдэн настайдаа бурханы хутгийг олсон он цагийн тухайд “Улаан дэвтэр”-ийн хэвлэлүүдэд өөр өөрөөр тэмдэглэжээ. Тухайлбал, Бээжингийн хэвлэлд гучин настайдаа, Сиккимийн хэвлэлд⁶ гучин таван настайдаа бурханы хутгийг олов хэмээжээ. Бурханы намтраас үзэхэд гучин таван настайдаа гэгээрсэн нь тодорхой буй. Үүнээс бусад мэдээ баримт нь илэрхий зөрөө байхгүй.

Мөн тус сурвалжид <<...үүнээс хойш найман жил болоод эхдээ ном номлохын тулд тэнгэрийн оронд заларсны хойно хаан Удрайна⁷ Моугалжибү-д дурдсанаар, тэр бээр тэнгэрийн оронд ялж төгс нөгчсөний лагшинг зандан модоор бүтээж, хүний ертөнцөд урин залав. Ялж төгс нөгчсөн тэнгэрээс буухын үед тэрхүү зандан лагшин ялж төгс нөгчсөнд /бурхан багшид. О.Д./ тэргүүн бөхийн ёслон мөргөвэй. “Гаслангаас нөгчиж мянган он өнгөрөхөд энэхүү лагшин Хятадын оронд амьтны тусыг бүтээх болмуй” хэмээн вивангирид /зөн билэг. О. Д./ үзүүлжээ. Түүнээс дөчин хоёр жил болоод наян настайдаа гаслангаас нөгчив. Ялгуусан нөгчсөнөөс усан гахай жил Сэцэн хаан⁸ ширээнд сууж, жилийг ялгасан лугаа гурав өнгөрсөн, түүнийг тоолсноор түүнээс дээшид хоёр мянга гучин он өнгөрчээ. Занданзууг бүтээснээс хоёр мянга тавин таван он өнгөрсөн хэмээн Хятадын Занданзуугийн түүхэнд буй ажгуу...>> хэмээн бичжээ.

Үүгээр үзвэл “Сэцэн хаан ширээнд суусан нь 1260 оны төмөр бич жил бөгөөд жилийг ялгасан лугаа гурав өнгөрсөн хэмээх нь Хубилай хаан сууринд суугаад гурван жил өнгөрсөн буюу 1263 оны усан гахай жил болох нь дамжиггүй юм. Учир нь тус сурвалжид “...усан гахай жилээс хойшид, эдүгээ гал нохой жилээс дээшид наян дөрвөн жил өнгөрчээ” гэж тэмдэглэсэн байгаа. Эдүгээ гал нохой жил гэдэг нь Цалба Гунгаадорж тус бүтээлээ туурвисан жилээ буюу 1346 оныг хэлж байгаа хэрэг. Үүнийг нягталбал 1263 оны усан гахай жилээс хойш 1346 оны гал нохой жил наян дөрвөн жил өнгөрсөн нь тохирч буй.

⁵ Хутагт 42 хэсэгт судар оршвой. Хятад, төвд, манж, монгол хэлээр хавсарсан. •

⁶ Сиккимийн Төвд судлалын Их сургуулиас “Улаан дэвтэр”-ийн төвд хэвлэлийг 1961 онд бараар хэвлэлийг 1961 онд бараар хэвлэсэн. Эдүгээ нэг хувь нь монгол улсын төв номын санд хадгалагдаж буй.

⁷ Энэтхэгийн нэгэн хязгаар орны хаан. Бурханд тун сүсэгтэй байсан гэж бурханы ном сударт дурдагддаг. Удрайна Моугалжийн хүүд дурдсанаар, тэр бээр тэнгэрийн оронд ялж төгс нөгчсөний лагшинг зандан модоор бүтээж, хүний ертөнцөд урин залсан гэдэг.

⁸ Сэцэн хаан хэмээх нь Хубилай хаан болой.

“...Түүнээс дээшид 2030 он өнгөрчээ” хэмээснээр усан гахай жилээс урагш тооцоолбол, НТӨ 768 оны усан тахиа жилд бурхан Шагжамуни нирваан дүр үзүүлжээ гэсэн үг болох юм. Шагжамунийн наян наснаа таалал барьсан нь түүх судар болон судалгааны бүтээлүүдэд нэгэнтээ эргэлзээгүй тул, тус усан тахиа жилээс, мэндэлсэн он жилийг мөшгин үзвэл НТӨ 847 оны модон бар жил болох юм. Гэтэл дээр тооцоолон дурдсан, мэндэлсний тухай дахь он жил нь үүнтэй мөн дүйцэхгүйгээр үл барам бурхан Шагжамунийн мэндэлсэн хийгээд нирваан дүр үзүүлсэн он цагийн асуудал, тухайн сурвалж дотроо зуун хориод жилээр зөрж байгаа юм. Гэтэл бас “Дөчин хоёр хэсэгт”-эд “...тэндээс Му вангийн тавин гуравдугаар он усан бичин жилийн 2 сарын 15-наа бурхан багш гаслангаас нөгчсөний дүр үзүүлвэй”⁹ гэжээ. Чжоу улсын 5 дугаар хаан Му ван НТӨ 976 оны хөхөгчин могой жил сууринд суусан тул, түүний 53 дугаар он нь 924 оны улаагчин тахиа жил тохионо. Үүнээс бурхан Шагжамунийн мэндэлсэн он жилийг мөшгивөл НТӨ 1003 оны шар бар жил болох юм.

Харин Монгол улсад Бурхан багшийн нирваан дүр үзүүлсний 2500 жилийн ойг 1956 оны 5 дугаар сарын 24-нд, Энэтхэгийн Дели хотноо 1956 оны 11 дүгээр сард тус тус тэмдэглэсэн нь эдүгээ олонхийн саналтай нийлдэг билээ.

Тэгэхлээр “Улаан дэвтэр” дэх энэхүү он цагийн асуудал нь “Дөчин хоёр хэсэгт”-ийн болон одоогоор баримталж буй үзлээс нэлээд зөрж буй ч “Дөчин хоёр хэсэгт”-ийн мэдээтэй харьцуулбал арай дөхөм байна.

2. Хятад оронд бурханы шашин анхлан дэлгэрсэн цаг үеийн асуудал.

“Улаан дэвтэр”-т зүүн Хань улсын 2 дугаар хаан Мин Ди-гийн үед “...бандида Зухалам /dzu ha lam/ хийгээд үнэнийг үзэгч хоёр бээр нэгэн цагаан моринд бага хөлгөний номыг ачиж, Хятадын оронд ирээд ... Бай Ма Сы /白马寺/ хийдийг байгуулан ном орчуулав. ... түүнээс эхлээд өнөө хүртэл бурханы шашин дэлгэрсэн болой”¹⁰ хэмээжээ.

Энд дурдаж буй Мин Ди хаан бол Хятадын зүүн Хань улсын 2 дугаар хаан, НТ 58 оны шар морин жил сууринд сууж, 7 дугаар ондоо Ван Цзунь зэргийн хүмүүсийг өрнө зүгт бурханы номыг эрүүлэхээр илгээсэнд, Энэтхэгийн бандида Зухалам /竺法兰/, архад Мадан¹¹ нар бурханы хөрөг, ном судар зэргийг нэгэн цагаан моринд ачиж, Хятадад залрах замд учраад хамтаар Лоян¹² хотод ирээд ном номлох үед Бай Май Сы хийдийг байгуулан, ном орчуулжээ¹³.

⁹ 42 хэсэгт сударын 756 дугаар тал.

¹⁰ Дунгарлуvsанпринлэй. *Улаан дэвтэрийн чухал үгнүүдийн товч тайлбар*. Үндэстний хэвлэлийн хороо. Төвд хэвлэл. 2004. 12 дугаар нүүрт. О. Дэмчигмаа. “Улаан дэвтэр”-ийн нэгэн төвд бичмэл эхийн орчуулга, эх бичгийн судалгаа”. Улаанбаатар. 2002 он. 23, 67 дугаар нүүр.

¹¹ Архад Мадан бол Энэтхэгийн бурханы шашныг дэлгэрүүлэгч. Улаан дэвтэрт Үнэнийг үзэгч гэж тэмдэглэжээ.

¹² Тухайн үеийн Зүүн Хань улсын нийслэл. Эдүгээ Хэнань мужид буй.

¹³ Дундад улсын бурханы шашны нийгэмлэгээс найруулсан “Дундад улсын бурханы шашин”. 1 дүгээр эмхтгэл. /хятад хэвлэл/. Жи Ши хэвлэлийн хороо. 1980 он. 4-5 дугаар нүүрт. Мөн Дунгарлуvsанпринлэйн дээрх номын 233-234 дүгээр нүүрт төвд хэлээр.

Ингэхлээр “Улаан дэвтэр”-ийн мэдээгээр бол Хятадад Хань Мин Ди хааны үед бурханы шашин энэ мэтээр анхлан дэлгэрсэн ажээ.

Харин бурханы шашны эхийг олсон нь үүнээс өмнө буюу баруун Хань улсын үе бөгөөд тэр үед амаар ном уламжилсан төдий л бололтой.¹⁴

3. Зүүн Цзинь улсын үеийн их шүтээнүүдийн тухайд.

“Улаан дэвтэр”-т <<...Гай Зин хааны¹⁵ үед Энэтхэгийн нэгэн бандида өвгөн бээр хаанд “Энэтхэг, Жан орны хоорондох нэгэн жижиг оронд урьд бурхан Шагжтүв гучин гурван оронд залрахад бүтээсэн шүтээн, бурханы арван насны лагшин Зуу Шагжа ба бурханы шарил хийгээд Гүмараши хэмээх мэргэн бандида буй. Түүнд орныг захируулсан тул амьтны тусыг үл арвижуулмуй. Та цэрэг илгээж авахаар одвоос олон амьтанд аугаа их тус болмуй” хэмээсэнд хаанд Чинсян түшмэл хийгээд хязгаарыг захирагч нэгэн жанжин буй тул, жанжнаа дөчин түм орчим цэрэг өгч тэр оронд илгээв. Тэр орноо хүрэхэд орны хаан << - Та бид өсгүй, өдий цэрэг ирэх нь юун буй” хэмээсэнд “- Зуу Шагжа хийгээд бурханы шарил, бандида гурвыг таалав. Эс өгвөөс цэрэг хөдөлгөмүй” хэмээхүйд, Зуу шагжа ба шарил бодтой буй тул өгөв. “Тэр бандида ноднин нөгчсөн. Түүний хөвгүүн арван найман настай Гүмарачүн хэмээгч буйг өгмүй” хэмээн өгчээ. Тэдгээрийг авч тэр жанжин буцав. ... Түүнээс тэр жанжин бээр хааны дэргэд хүрэхэд Гай Зин хаан лагшин ажирч, залгамжлал тасраад урьдын Чинсян хаан болсныг сонсч, тэр бээр /жанжин. О. Д./ дөчин түмэн цэргээ хурааж, Си Чон /Сичуань=Лян Дү/ хийгээд хорин дөрвөн Чжоу хотын хаан болов.

Хожим жанжны үе залгамжлалын ургаас Чинсян хааны залгамжлал бээр Зуу Шагжа, шарил, бандида нугуудыг Гин За Ху /тухайн үеийн хойд Цинь-ийн нийслэл Чан Ань. О. Д./-д урин залаад... >>¹⁶ хэмээн тэмдэглэсэн байна.

Тус сурвалжийн энэ мэдээг нягталбал Түрүү Цинь-ий хаан Фу Жянь /苻坚/-д Энэтхэгийн бандида өвгөн бээр Гүмарашийг онцлон танилцуулж, дурдагдаж бүхий шүтээнүүдийг түүний хамт урин залахыг сануулснаар хаан, баруун хязгаар орныг төвшитгөгч жанжин Люй Гуан-д цэрэг өгч тэр оронд явуулж, шүтээнүүдийг Чан Ань-д урин залж ирэхийг зарлигджээ¹⁷. Сурвалжид дурдагдаж буй, эдгээр шүтээнүүд хадгалагдаж байсан, тэр жижиг орон бол Ли орон болох бөгөөд эдүгээгийн Шинжаан-

¹⁴ Дундад улсын бурханы урсгал бүлгийн талаарх товч лекц. Жүн Хуа номын товчоо. /хятад хэвлэл/. 1982 он. 19 дүгээр нүүр. Вүй Чан Хун. Баруун хязгаар орны бурханы шашны түүх. Шинжааны уран зургийн хэвлэлийн хороо. /хятад хэвлэл/. 1998 он. 22 дугаар нүүр. Д. Цэрэнсодном. Монголын бурханы шашны уран зохиол. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2001 он. 84 дүгээр нүүр. Дундад улсын бурханы шашин. 1980 он. 1 дүгээр эмхтгэл. 3-5 дугаар нүүр.

¹⁵ Мэдээ сурвалжаас үзэхэд Гай Зин хаан хэмээх нь Түрүү Цинь улсын Фу Жянь хаан мөн бололтой. Энэ хаан НТ 357-383 оны хооронд сууринд суужээ.

¹⁶ Дүнгэрлүвсанпринлэй. Улаан дэвтэрийн чухал үгсийн товч тайлбар. Үндэстний хэвлэлийн хороо. Төвд хэвлэл. 2004. 13-14 дүгээр нүүрт.

О. Дэмчигмаа. “Улаан дэвтэр”-ийн нэгэн төвд бичмэл эхийн орчуулга, эх бичгийн судалгаа. Улаанбаатар. 2002 он. 25-26 дугаар нүүр.

¹⁷ Вүй Чан Хун. Баруун хязгаар орны бурханы шашны түүх. Шинжааны уран зургийн хэвлэлийн хороо. /хятад хэвлэл/. 1998 он. 37 дугаар нүүр.

Уйгурын Өөртөө Засах Орны Агсү /газрын нэр. О. Д./-гийн Кү Чэ сянь - /засаг захиргааны нэг жижиг нэгж. О. Д./-ийг хэлж буй. Люй Гуан жанжин тэнд хүрч уг шүтээнүүдийг залаад, буцан ирэх үест Түрүү Цинь-ийн хаан Фу Жянь-ий Чинсян, Цян /тангад/ угсааны Яо Чан хаанаа хороож, өөрийгөө хаан өргөмжилснийг¹⁸ сонсоод, тэр бээр цэргээ хурааж Лянчжоу-г байгуулаад, Гу Цзан-д нийслэллэж, төрөө Хожуу Лян улс хэмээн нэрлэжээ. Арван зургаан жилийн дараа Хожуу Цинь-ий Яо Шин¹⁹ Люй Гуан-ы байгуулсан Лян улсыг мөхөөж, түүний угсааныхнаас Занданзуу тэргүүтэн шүтээнийг Чан Ань-д аваачин залж, сүм хийд байгуулан Гүмараши бандидаар хятад хэлэнд олон зарлиг шастирыг орчуулгажээ²⁰.

Гүмараши бандида /НТ 344-412/ Ли оронд төрсөн. Түүний эцэг Гүмараян гэдэг энэтхэг хүн, эх нь Ли орны нэгэн хааны охин байжээ. Гүмараши багадаа тойн болсон хийгээд Кашмир оронд хүрч ном сурч судлаад, хожим нь их хөлгөний номд орж, төв үзлийг баримтлагч их бандида болжээ. Тэгээд Энэтхэгийн баруун зүгийн орнуудаар заларч, ном олонтаа номлосон бөгөөд Түрүү Цинь улсын хаан Фу Жянь-ий 18 дугаар /НТ 382| онд Ли орондоо буцаж ирсний хойно НТ 385 онд Лянчжоу-д залагдаж, арван зургаан жил шүтэгдсэн аж. Тэрбээр хятад, төвд хэлийг нэвтэрхий мэддэг нэгэн байсан хэмээн түүхэнд тэмдэглэгдсэн байх агаад Хожуу Цинь улсын хаан Яо Шин 3 дугаар оныхоо төмөр үхэр /401 он/ жил Чан Ань-д багшийн ёсоор хүндлэн залах үед тавин долоон сүүдэртэй байжээ. Тэнд өнгөрөөсөн арван гурван жилийн хугацаандаа “Доржзодба” тэргүүтэн “Билигийн чанад хязгаараа хүрэх их бага элдэв судар” хийгээд “Дээдийн ном цагаан лянхуа”, “Димэддагба бээр номлосон судар” тэргүүтэн олон судар, Нагаржунай “Төв үзлийн билгийн Үндсэн”, “Төв үзлийн арван хоёр үүд”, Ловон Пагвалха-гийн /Арьяадэва. О. Д./ зохиол гэж алдаршсан “Билгийн чанад хязгаарт хүрэх зуун их бүлэгт” сэлт гурван зуун дөрвөн хэсэг бүлгийг хятад хэлэнд орчуулсны зэрэгцээ олон шавь нарыг ч тэтгэн, далан насныхаа усан хулгана жил /412 он/ гаслангаас нөгчжээ.

Гэтэл “Улаан дэвтэр”-т “...тэр бандида ноднин нөгчсөн. Түүний хөвгүүн арван найман настай Гүмарачүн хэмээгч буйг өгмүй” хэмээснийг түүхийн судалгааны эдгээр мэдээ баримтаар үндэслэвэл Гүмараши тухайн үед амьд сэрүүн байснаар үл барам далан нас хүртлээ бусад орон газруудад залагдан шүтэгдэж, мөн Хятад, Төвдийн соёл хийгээд соёлын харилцаанд түүхэн хувь нэмрийг оруулсан мэргэн бандида ажээ.

Мөн шүтээнүүдийн нэг болох Занданзууг Бурхан Шагжамуни гучин гурван тэнгэрийн оронд эхдээ ном номлохоор гурван сар залрах хооронд Энэтхэгийн Варанасийн хаан Удраяна санан уйтгарлаад, Моугалжийн хүүд бурханы хөргийг бүтээхийг дурдсанаар, тэр бээр тэнгэрийн оронд очиж гошри /цагаан зандан. О. Д./

¹⁸ Чинсян хэмээх нь хааны их түшмэлийн албан тушаалын зэргийг хэлж буй. Яо Чан хэмээгч нь Фу Жянь хааны их түшмэл байсан бөгөөд хаан нь НТ 383 дайнд яваад эзгүй хойгуур НТ 384 онд ван сууж, улсаа Хожуу Цинь гэж нэрлээд, хааныгаа буцаж ирэхэд нь хороогоод 386 онд өөрийгөө хаан өргөмжилж, 393 он хүртэл сууринд суужээ.

¹⁹ Энэ хаан бол Хожуу Цинь-ий 2 дугаар хаан.

²⁰ Дунгарлуванпринлэй. *Цагаан лавайн их толь бичиг*. Төвд хэлээр. Дундад улсын Төвд судлалын хэвлэлийн хороо. 2002. 1653 дугаа нүүр.

зандангаар лагшинг бүтээж хүний ертөнцөд залжээ²¹. Энэхүү зандан лагшин урьдаар Энэтхэг оронд тахигдаж байгаад хожим нь Ли оронд жаран найман жилийн турш шүтэгдээд, Гүмараши болон бусад шүтээний хамтаар НТ 385 онд Лянчжоу-д, дараагаар нь мөн шүтээнүүдтэй Чан Ань-д залагдан, Ху Нань, Жян Нань зэрэг газрын олон хаадын тахилын орон болсоор байсныг сүүлд Зүрчидийн Алтан улсын үед Бээжингийн хааны ордонд авчран, Нин Чжун Сы сүмд залжээ.

“Улаан дэвтэр”-ийн зохиогч Цалба Гунгаадорж, Хятадын түүхтэй холбогдох эдгээр хэсгийг бичихдээ төвдөөр орчуулсан хятад сурвалжуудыг ашигласнаа дурджээ. Тухайлбал: Бурханы шашны он тоололтой холбогдох хэсгийг “Хятадын түүх бичиг”-үүдээс, цаашлаад Хятадад шашин анхлан дэлгэрсэн болоод шүтээнүүдийн талаарх мэдээг Хятадын хуучин түүх дэвтрээс тус тус ашиглажээ. Энэ нь Хятад оронд шашин эрт дэлгэрсэн хийгээд улмаар Хятад, Төвд хоёр орон түүх, соёлын өргөн харилцаатай байсныг илтгэж буй хэрэг.

Тэгэхлээр “Улаан дэвтэр” хэмээх энэхүү төвд сурвалжаар дамжин Хятадын түүх, сурвалжийн мэдээг судалгаа шинжилгээний ажилд ашиглах илүү өргөн боломжийг олгож өгч байгаа нь бас нэг давуу тал болох юм.

²¹ Дунгарлуvsанпринлэй. *Цагаан лавайн их толь бичиг*. Төвд хэлээр. Дундад улсын Төвд судлалын хэвлэлийн хороо. 2002. 1652 дугаар нүүр.